

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар анхаарал хандуулах болон анхаарал татахуйц асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал.....	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ
Т.БАДРАЛ ТАНАА

2019.02.25 № 06/276
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 01-нээс 2019 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай, аудитор Ц.Цэрэнхүү нар хариуцаж хэрэгжүүлэв.

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 9/166 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Онцгой байдлын ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Онцгой байдлын ерөнхий газар Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхийг нэмэгдүүлэх нь гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг болзошгүй гамшгийн аюулаас хамгаалах
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах

Онцгой байдлын ерөнхий газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Онцгой байдлын ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Онцгой байдлын ерөнхий газар 2018 оны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Онцгой байдлын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Онцгой байдлын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувийг сонгов.

Төлөвлөлтийн шатанд сонгосон материаллаг байдлын суурь, нийт зардлыг гүйцэтгэлийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Сүүлийн хагас жилд зардлын дүн өссөнтэй холбоотойгоор эрсдэлийг өндөр гэж үзэж, материаллаг байдлын хувийг 1.0 хувь болгон бууруулсан болно.

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардал нь 37,490,416.5 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 374,979.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 10 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

				/мянган төгрөгөөр/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	180,342.0	
	Дүн	2	180,342.0	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тайлант онд 10,000.0 мянган төгрөгийн хандиваар авсан бараа материалыг шууд зардалд бүртгэсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу 112,829.6 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн, санхүүгийн тайлангаарх авлага, өглөгийг тулган шалгахад 2,891.9 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, 657,102.3 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэсэн.

2. Хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй 3,500.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад барагдуулсан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад нийт 786,823.8 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан.

2.9 Дараагийн аудитаар анхаарал хандуулах болон анхаарал татахуйц асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад асуудал байхгүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Онцгой байдлын ерөнхий газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 19,890,335.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 19,502,551.6 мянган төгрөг буюу 98.05 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 367,436.4 мянган, байр ашиглалтын зардал 17,365.8 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний зардал 2,971.5 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 10.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсанаас шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Онцгой байдлын ерөнхий газар аппарат Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тайлант онд Онцгой байдлын ерөнхий газрын урсгал төсвийн, нэмэлт санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын, барьцаа хөрөнгийн дансны холбогдох мэдээллүүдийг шилэн дансны сайтанд тухай бүр бүрэн оруулсан байна. Мөн албан хаагчдад зориулсан мэдээллийн самбарт байгууллагын тухайн жилийн батлагдсан төсөв, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, цалингаас

бусад 5.0 сая төгрөгнөөс дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээ, бусад мэдээллийг байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Онцгой байдлын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Батлагдсан төсөв, гүйцэтгэл

1.1. Илрүүлэлт:

Нийт 13,560.8 мянган төгрөгийг спортын мастерын нэмэгдлийг үндэслэлгүйгээр олгосон, гадаад томилолтын зардлын хэмжээг мөрдөөгүйгээс 1,856.5 мянган төгрөгийг илүү зарцуулсан.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүйгээс гадна Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан журмын холбогдох заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг үнэн зөв, зориулалтын дагуу зарцуулах,

1.3. Зөвлөмж:

Үндэслэлгүй нэмэгдэл олгохыг зогсоох, гадаад томилолтын зардлын хэмжээг мөрдөж байх,

1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.

2. Санхүүгийн тайлангийн тодруулга

2.1. Илрүүлэлт:

Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр урсгал зардлаас 164,924.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.

Энэ нь ТӨБЗГ-ын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.4-т "Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар нь ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагаар эд хөрөнгө худалдаж авах тохиолдолд санхүүгийн эх үүсвэрээ эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсний дараа ТӨБЗГ-т тавьж зохих зөвшөөрөл авна." гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр хөрөнгө бэлтгэсэн байх,

2.3. Зөвлөмж:

Хөрөнгө бэлтгэхдээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч байх,

2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Дээр дурдсан алдаа, зөрчлийг Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,228,974,285.88</u>	<u>5,679,165,042.11</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	222,000.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	222,000.00	00.00
3121	Төгрөг	222,000.00	00.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	222,000.00	00.00
33	АВЛАГА	2,104,969,668.37	760,245,716.16
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,104,969,668.37	760,245,716.16
34	УРЬДЧИЛГАА	84,649,250.00	166,790,533.28
34600	Урьдчилж гарсан зардал	84,649,250.00	166,790,533.28
35	БАРАА МАТЕРИАЛ	4,039,133,367.51	4,752,128,792.67
351	Түүхий эд материал	555,140,844.64	1,161,310,809.01
35110	Тусгай зориулалттай материал	555,140,844.64	1,161,310,809.01
354	Хангамжийн материал	3,476,104,522.87	3,590,817,983.66
35410	Бичиг хэргийн материал	159,596,789.76	269,411,278.62
35420	Аж ахуйн материал	148,154,828.39	100,101,434.01
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	5,820,000.00
35460	Хүнсний материал	174,148,693.00	39,233,985.00
35470	Бусад хангамжийн материал	2,994,204,211.72	3,176,251,286.03
35600	Мал амьтад	7,888,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,488,296,860.84</u>	<u>7,260,849,009.09</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,488,296,860.84	7,260,849,009.09
392	Биет хөрөнгө	6,488,296,860.84	6,940,420,922.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,156,024,619.00	3,544,920,635.79
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,736,845,632.33	-37,764,702.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,278,235,653.57	10,539,435,288.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,374,448,993.26	-7,325,546,305.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	461,891,252.37	547,248,179.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-296,560,038.51	-328,886,717.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	13,557,495.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-12,542,952.48
393	Биет бус хөрөнгө	00.00	320,428,086.65
39301	Програм хангамж	13,301,820.80	13,551,820.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	-13,301,820.80	-13,322,654.15
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	320,198,920.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>12,717,271,146.72</u>	<u>12,940,014,051.20</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,744,070,201.00</u>	<u>5,785,222,606.16</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,744,070,201.00	5,785,222,606.16
413	Өглөг	2,744,070,201.00	5,785,222,606.16
4136	Бусад өглөг	2,744,070,201.00	5,785,222,606.16
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	809,866,767.16

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,744,070,201.00	4,975,355,839.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,973,200,945.72	7,154,791,445.04
51	Засгийн газрын хувь оролцоо	9,973,200,945.72	7,154,791,445.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	149,888,645.96	470,087,565.96
51101	Өмч: - төрийн	149,888,645.96	470,087,565.96
512	Хуримтлагдсан үр дүн	9,224,925,526.56	4,199,300,225.21
51210	Өмнөх үеийн үр дүн	3,912,190,867.43	9,224,925,526.56
51220	Тайлант үеийн үр дүн	5,312,734,659.13	-5,025,625,301.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	598,386,773.20	2,485,403,653.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,717,271,146.72	12,940,014,051.20

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32,721,101,500.50	32,472,273,623.08
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,243,966,240.13	833,881,656.29
120	Нийтлэг татварын бус орлого	6,788,306,993.94	833,881,656.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,786,554,508.69	833,881,656.29
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,752,485.25	3,462,243.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,784,802,023.44	830,419,413.29
120009	Бусад орлого	1,752,485.25	00.00
122	Тусламжийн орлого	455,659,246.19	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	455,659,246.19	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,477,135,260.37	31,638,391,966.79
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,654,892,300.00	19,890,335,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,654,892,300.00	19,890,335,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,822,242,960.37	11,748,056,566.79
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,403,439,498.37	265,926,376.79
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,455,222,462.00	11,439,900,826.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	942,581,000.00	42,229,364.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	27,383,181,463.95	37,490,416,481.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,383,181,463.95	37,490,416,481.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,516,274,626.74	24,339,247,472.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,815,837,126.81	1,743,323,100.00
210101	Үндсэн цалин	1,198,733,130.65	1,015,312,300.00
210102	Нэмэгдэл	544,840,696.16	645,900,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,263,300.00	82,110,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,090,134.74	58,460,803.07
210201	Тэтгэврийн даатгал	41,090,134.74	24,839,021.79
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	9,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	33,612,181.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	179,859,865.78	199,072,520.94
210301	Гэрэл, цахилгаан	109,469,375.34	117,729,009.04
210302	Түлш, халаалт	51,877,430.15	57,224,282.81
210303	Цэвэр, бохир ус	5,684,117.29	4,708,898.09
210304	Байрны түрээс	12,828,943.00	19,410,331.00
2104	Хангамж, бараа материалын зардал	205,096,203.39	432,805,563.97
210401	Бичиг хэрэг	44,783,530.00	120,611,783.00
210402	Тээвэр, шатахуун	98,305,000.00	8,382,409.00

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,618,663.39	42,918,334.53
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,358,000.00	1,655,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,031,010.00	259,238,037.44
2105	Нормативт зардал	228,838,563.00	2,229,045,654.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,479,430.00	972,166.00
210502	Хоол, хүнс	19,003,466.00	28,510,041.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	205,355,667.00	2,199,563,447.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,320,611,483.40	1,793,578,560.37
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,341,449.00	176,848,545.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,286,326,215.40	1,105,290,607.37
210604	Урсгал засвар	27,943,819.00	511,439,408.00
2107	Томилолт, зочны зардал	9,650,200.00	11,997,730.00
210702	Дотоод албан томилолт	9,650,200.00	11,997,730.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	716,740,943.03	3,227,808,325.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	369,306,837.03	2,907,453,288.88
210803	Даатгалын үйлчилгээ	343,129,250.00	318,544,156.72
210807	Газрын төлбөр	4,304,856.00	1,810,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,998,550,106.59	14,643,155,214.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,019,587,967.64	12,511,370,414.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,726,858.00	73,375,846.25
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,920,875,280.95	2,058,408,953.80
210904	Найдваргүй авлагын алдагдал	3,360,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	866,906,837.21	13,151,169,008.37
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	55,600,182.00	55,600,778.28
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	55,600,182.00	55,600,778.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	286,458,205.00	11,943,479,482.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	142,801,906.00	170,284,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	111,310,299.00	11,768,695,282.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,846,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	524,848,450.21	1,152,088,748.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	524,848,450.21	1,152,088,748.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,337,920,036.55	-5,018,142,858.09
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,432,892.17	7,482,443.26
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	23,432,892.17	7,482,443.26
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-23,432,892.17	-7,482,443.26
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,314,487,144.38	-5,025,625,301.35

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	25,478,887,745.62	33,745,240,467.16
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,752,485.25	1,878,832.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,752,485.25	1,878,832.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,752,485.25	1,878,832.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,878,832.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,752,485.25	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,477,135,260.37	33,743,361,635.16
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,654,892,300.00	19,890,335,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,654,892,300.00	19,890,335,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,822,242,960.37	13,853,026,235.16
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,403,439,498.37	1,687,896,045.16
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,455,222,462.00	11,439,900,826.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	942,581,000.00	725,229,364.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	25,438,393,245.62	33,580,537,543.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,438,393,245.62	33,580,537,543.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,931,224,555.04	22,627,255,216.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,815,837,126.81	1,743,323,100.00
210101	Үндсэн цалин	1,198,733,130.65	1,015,312,300.00
210102	Нэмэгдэл	544,840,696.16	645,900,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,263,300.00	82,110,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,090,134.74	58,460,803.07
210201	Тэтгэврийн даатгал	41,090,134.74	43,077,629.93
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	4,726,106.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	10,657,067.14
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,188,865.78	204,946,289.94
210301	Гэрэл, цахилгаан	109,469,375.34	117,729,009.04
210302	Түлш, халаалт	51,877,430.15	57,224,282.81
210303	Цэвэр, бохир ус	5,684,117.29	4,708,898.09

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210304	Байрны түрээс	16,157,943.00	25,284,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	217,303,343.39	146,877,968.00
210401	Бичиг хэрэг	18,576,780.00	25,870,200.00
210402	Тээвэр, шатахуун	98,305,000.00	6,461,768.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,618,663.39	42,805,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,358,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	57,444,900.00	69,740,200.00
2105	Нормативт зардал	2,804,990,636.85	3,121,579,373.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,487,810.00	1,683,000.00
210502	Хоол, хүнс	17,684,358.00	31,552,973.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,781,818,468.85	3,088,343,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	255,504,377.80	557,003,410.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	99,020,475.80	114,957,610.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,164,000.00	157,442,400.00
210604	Урсгал засвар	148,319,902.00	284,603,400.00
2107	Томилолт, зочны зардал	9,650,200.00	18,467,200.00
210702	Дотоод албан томилолт	9,650,200.00	18,467,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	793,214,993.03	3,423,370,436.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	445,119,637.03	3,070,824,116.27
210803	Даатгалын үйлчилгээ	343,790,500.00	350,735,440.00
210807	Газрын төлбөр	4,304,856.00	1,810,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,810,444,876.64	13,353,226,636.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,745,335,428.64	13,274,455,087.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	65,109,448.00	78,771,549.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,507,168,690.58	10,953,282,326.37
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	55,600,182.00	55,600,778.28
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	55,600,182.00	55,600,778.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,821,750,390.00	9,745,592,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	241,491,790.00	371,148,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,547,912,600.00	9,369,944,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,846,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,629,818,118.58	1,152,088,748.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,629,818,118.58	1,152,088,748.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>40,494,500.00</u>	<u>164,702,924.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	40,494,500.00	164,924,924.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,494,500.00	164,924,924.00
2200	Дотоод эх үүсвэрээр	40,494,500.00	164,924,924.00

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	40,494,500.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	164,924,924.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-40,494,500.00</u>	<u>-164,924,924.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	-222,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	222,000.00	222,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	222,000.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	149,888,645.96	598,386,773.20	9,224,925,526.56	9,973,200,945.72
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	149,888,645.96	598,386,773.20	9,224,925,526.56	9,973,200,945.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	149,888,645.96	598,386,773.20	9,224,925,526.56	9,973,200,945.72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		1,887,016,880.67	00.00	1,887,016,880.67
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	320,198,920.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,025,625,301.35	-4,705,426,381.35
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,087,565.96	2,485,403,653.87	4,199,300,225.21	7,154,791,445.04

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,890,335,400.00	19,502,551,604.07	387,783,795.93	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,890,335,400.00	19,502,551,604.07	387,783,795.93	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,089,141,800.00	9,701,358,025.79	387,783,774.21	96.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,743,323,100.00	1,743,323,100.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	1,015,312,300.00	1,015,312,300.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл	645,900,500.00	645,900,500.00	0.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	82,110,300.00	82,110,300.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	425,897,200.00	58,460,803.07	367,436,396.93	13.7
210201	Тэтгэврийн даатгал	305,225,200.00	43,077,629.93	262,147,570.07	14.1
210202	Тэтгэмжийн даатгал	45,125,400.00	4,726,106.00	40,399,294.00	10.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	31,280,700.00	00.00	31,280,700.00	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	8,693,300.00	00.00	8,693,300.00	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	35,572,600.00	10,657,067.14	24,915,532.86	30.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,312,100.00	204,946,289.94	17,365,810.06	92.2
210301	Гэрэл, цахилгаан	135,459,200.00	117,729,009.04	17,730,190.96	86.9
210302	Түлш, халаалт	54,600,000.00	57,224,282.81	-2,624,282.81	104.8
210303	Цэвэр, бохир ус	6,968,800.00	4,708,898.09	2,259,901.91	67.6
210304	Байрны түрээс	25,284,100.00	25,284,100.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	136,249,200.00	136,249,200.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	21,903,200.00	21,903,200.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,605,800.00	42,605,800.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	69,740,200.00	69,740,200.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	3,093,099,400.00	3,093,099,373.26	26.74	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,683,000.00	1,683,000.00	0.00	100.0

Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	27,673,000.00	27,672,973.26	26.74	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,063,743,400.00	3,063,743,400.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	677,811,300.00	677,811,300.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	235,765,500.00	235,765,500.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	157,442,400.00	157,442,400.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	284,603,400.00	284,603,400.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	12,169,200.00	12,169,200.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	12,169,200.00	12,169,200.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,468,746,200.00	3,465,774,670.27	2,971,529.73	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,113,232,900.00	3,113,228,350.27	4,549.73	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	350,761,300.00	350,735,440.00	25,860.00	100.0
210807	Газрын төлбөр	4,752,000.00	1,810,880.00	2,941,120.00	38.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	309534100.00	309524089.25	10,010.75	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	239,241,900.00	239,231,890.00	10,010.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	70,292,200.00	70,292,199.25	0.75	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9801193600.00	9801193578.28	21.72	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	55,600,800.00	55,600,778.28	21.72	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	55,600,800.00	55,600,778.28	21.72	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,745,592,800.00	9,745,592,800.00	0.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	371,148,700.00	371,148,700.00	0.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,369,944,100.00	9,369,944,100.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,890,335,400.00	19,502,551,604.07	387,783,795.93	98.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,890,335,400.00	19,502,551,604.07	387,783,795.93	98.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	19,890,335,400.00	19,502,551,604.07	387,783,795.93	98.1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	105	105	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	02	02	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	103	103	0.00	100.0

4.6 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.22	Аудитын нэр:	Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/265/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Онцгой байдлын ерөнхий газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	3	4	5	9	10
1	Спортын мастерын нэмэгдлийг үндэслэлгүйгээр олгосон, гадаад томилолтын зардлын хэмжээг мөрдөөгүй	15,417.1	Зөвлөмж	СХХОГ-ын дарга Нягтлан бодогч	Я.Гантөмөр Г.Бат-Эрдэнэ
2	ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүйгээр урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн	164,924.9	Зөвлөмж	СХХОГ-ын дарга Нягтлан бодогч	Я.Гантөмөр Г.Бат-Эрдэнэ
Нийт		180,342.0			

